

# ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО

Захирамж 1/2020

Хамгийн сүүлд хийсэн нэмэлт өөрчлөлтийг баталсан огноо	20/02/2020
Сүүлд нэмэлт өөрчлөлт оруулсан	Тереза Дубенска
Баталсан (Үйл явцын шийдвэр гаргагч)	Якуб Личка
Гарын үсэг	
Баримт бичиг эзэмшигч	Үйл явцын менежер
Боломжтой хэл	<input checked="" type="checkbox"/> Чех <input checked="" type="checkbox"/> Англи
Талархал	Энэхүү баримт бичиг нь Ливан дахь Каритасын Хүрээлэн буй орчны бодлогыг ашиглаж боловсруулсан хувилбар болно. КЧР нь Ливан дахь Каритастан энэ журмыг боловсруулахад дэмжлэг үзүүлсэнд талархаж байна.

## **1 Бодлогын мэдэгдэл ба Зорилго**

Каритас Чех Репаблик нь хүрээлэн буй орчныг хамгаалах нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдлыг болон уг сэдвийг өөрийнхөө стратегийн шийдвэр гаргах үйл явцууд, өдөр тутмын үйл ажиллагаанд баримтлах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Энэхүү бодлого нь дараах зорилготой болно:

- КЧР нь хүрээлэн буй орчны талаарх мэдлэг, үүрэг хариуцлагын хувьд шийдэмгий байр суурьтай байгаа гэдгийг үүгээр албажуулах.
- Байгууллага дотроо хүрээлэн буй орчны талаарх үүрэг хариуцлагын мэдлэгийг сурталчлах.
- КЧР-ийн хөтөлбөрүүдийг уг Бодлогод заасан зорилгын хүрээнд хүрээлэн буй орчинд тогтвортой байх байдлаар хэрэгжүүлэх.

## **2 Бодлого**

### **2.1 Хандлага**

КЧР-ийн хүрээлэн буй орчны талаарх үүрэг хариуцлагатай холбоотой чиг хандлага нь Каритас Интернационалис байгууллагын хүрээлэн буй орчны тухай удирдамжид үндэслэгдсэн болно.

### **2.2 Ерөнхий зорилт**

КЧР нь байгаль болон үйл ажиллагаа, үйлчилгээнээс нь байгаль орчинд үзүүлэх нөлөөг удирдах үүрэг хариуцлагатай гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Уг бодлогын тогтолцооны хүрээнд КЧР нь боломжийн гэж үзсэн хэмжээнд хүртэл дараах зүйлд хүрэхийг эрхэмлэнэ:

- Орон нутгийн, үндэсний болон даян дэлхийн байгаль орчныг сайжруулахад ерөнхийдөө хувь нэмэр оруулах
- Орон нутгийн, үндэсний болон даян дэлхийн холбогдох хүрээлэн буй орчны талаарх хууль тогтоомж, бодлогын механизм, батлагдсан практик дадлын код, хэм хэмжээнд идэвхтэйгээр нийцсэн байх.
- Тогтвортой байдлын болон хүрээлэн буй орчныг хамгаалах зарчмуудыг сурталчлах.
- Байгууллагын хүрээлэн буй орчинд үзүүлж буй үр нөлөөний талаар ажилтан нарынхаа мэдлэгийг нэмэгдүүлэх ба тус Байгууллагын байрыг ашиглахтай холбогдсон хувь хүний сайн дадлыг сурталчлан төлөвшүүлэх.

- Аюулгүй бөгөөд эрүүл ажлын байраар хангах ба бүх ажилтан нар хүрээлэн буй орчны хариуцлагатай дадлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, сургалт, хэрэгслүүдээр хангагдсан болохыг баталгаажуулах.
- Эрчим хүч болон бусад нөөцийг хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх ба хог хаягдлын хэмжээг болон хүрээлэн буй орчинд аюултай бодис ялгаруулахыг бууруулах.

- Хүрээлэн буй орчинд хор хөнөөлтэй бодис, үйл явцуудыг хэрэглэхээс шаардлагагүй гэж үзсэн бол зайлсхийх.
- Үр ашигтай ашиглах, нарийн төлөвлөлт хийх замаар нөхөн сэргээгдэх байгалийн нөөцийг тогтвортой ашиглаж, нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөцийг хадгалах.
- Төсөл боловсруулах, хангамж, үйлчилгээ худалдан авахдаа хүрээлэн буй орчинд ээлтэй сонголтыг хэрэгжүүлэх.
- Байгууллагын нутаг дэвсгэр, барилга байгууламжийг хамгаалахад хөгжлийн болон засвар үйлчилгээний бүх ажилд хүрээлэн буй орчны хамгийн сайн дадал, туршлагыг хамруулж, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг судлах.
- Эрчим хүчний хэмнэлттэй, дотоодод үйлдвэрлэсэн, дахин боловсруулсан ба/эсхүл сэргээгдэх материалаар хийсэн бүтээгдэхүүн бүхий байгаль орчинд ээлтэй бараа бүтээгдэхүүн худалдан авдаг байх. Боломжийн хэрээр орон нутгийн ба/эсхүл хүрээлэн буй орчны тогтвортой байдлын сорилтын талаар тууштай ханган нийлүүлэгчдэд тендер зарладаг байх.
- Төлөвлөлтийн үе шатанд Үр нөлөө ба Эрсдлийн үнэлгээ хийж, шаардлагатай бол үйл ажиллагаа эхлэхийн өмнө тухайн сайтад тохирсон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулдаг байх.
- Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний болон санхүүгийн нөөцөөр хангах.

### **2.3 Үүрэг роль ба хариуцлага**

КЧР-ийн хүрээлэн буй орчны Бодлогыг дагаж мөрдөх нь КЧР-ийн бүх ажилтан нарын, үүнд мөн гадаад томилолтоор ирж ажиллаж буй бүх нийт ажилтан нарын үүрэг хариуцлага мөн.

## **3 Товчлолын жагсаалт**

